

Орон бүхний пролетариат нар нэгдэгтүн!

АНХ ДУГААР

ТАВАН ЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, А.ДХ-ын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь
жилдээ

№ 42 (2306)

1974 оны 6 дугаар сарын 1

БЯМБА

БАЯСГАЛАНТ ИРЭЭДҮЙ

Дэлхийн ардчилсан эмэгтэйчүүдийн холбооны зөвлөлийн чуулган, НҮБ-ын ерөнхий ассамблейн чуулганаар баталсан хүүхдийн эрхийн тунхагийн энэрэнгүй сайхан зарчмыг хэрэгжүүлэхийн тулд жил бүрийн 6 дугаар сарын 1-ний өдрийг олон улсын хүүхдийн хамгаалах өдөр болгожээ.

Энэхүү байрт өдрийн анх 1950 оноос хойш 25 дахь удаагаа төмдөлж байна.

Манай эрин үед секунд бүрт 3 шинэ хүн мэндэлж эх зүйлнхээ баяр хөөр болж байна.

Хүн төрөлхтөний баясгалант ирээдүй болсон хүүхэд багачуудын төлөө дэлхийн улс түмэн, түүний дотор ах дүү социалист орнууд ихээхэн анхаарал халамж тавьж байдаг билээ.

Коммунизмын эх орон ЗХУ-д 100 мянга нүү хүүхдийн эмч, эх баригчид эх нялхсын эрүүл мэндийг хамгаалахад ариун хөдөлмөрөө зориулж байна.

Манай оронд 1951 онд хүүхдийн хамгаалах хороо байгуулагджээ. Манай нам, засгаас өсвөрийн үеийнхний тал бүрийн мэдлэгтэй, цэвэр ариун ёс суртахуунтай, социализм коммунизмын үйл хэрэгт үнэнч иргэд болгон сургаж хүмүүжүүлэхийг онцгойдон анхаарч, өсвөрийн үеийнхний хүмүүжил боловсролын асуудлыг төрийн болон бүх нийтийн хэрэг болгон тавьж байна. Ийнхүү хүүхдийн төлөө тавьж байгаа анхаарал халамжийн ачаар манай улсад ардын боловсролын талаар тавьсан зорилтууд амжилттай биелэн, сургуулийн насны бүх хүүхдийг 8 жилийн боловсролтой болгох, ерөнхий боловсролын дунд сургуулийг сургалтын шинэ системд шилжүүлэх асуудал амьдралд хэрэгжин биелж, одоо манай улсын 547 сургуульд 274 мянга гаруй охид, хөвгүүд сурч түүнд дээд, тусгай дунд мэргэжлийн 10 мянга гаруй багш, сурган хүмүүжүүлэгчид өсвөр үеийнхний ирээдүйн төлөө хүч хөдөлмөрөө зориулж байна.

Тус аймгийн 30 сургуульд 12 мянга гаруй сурагчид, 32 цэцэрлэгт 1700 гаруй хүүхэд сурч хүмүүжиж байна.

Хүүхдийн төлөө тавьж байгаа анхаарал халамжийн нэг бол хүүхдийн төлөө фонд байгуулан хүүхдийн хүмүүжүүлэх асуудлыг бүх нийтийн үйлс болгон хэрэгжүүлж байгаа явдал юм.

1973 онд тус аймгийн Дэлгэрхаан суманд 25 хүүхдийн иж бүрэн төхөөрөмж бүхий цэцэрлэгийн барилгыг хүүхдийн төлөө фондын хөрөнгөөр барьж ашиглалтанд өглөө. 1973 онд манай аймаг хүүхдийн төлөө фондоод 163900 төгрөг хуримтлуулсан бөгөөд 1974 онд хөрөнгө хуримтлуулах энэ ажилд Заамарын ТМС, Ойн аж ахуй, Соёлын ордон, аймгийн ХЗЭ-ийн хороо зэрэг газрууд сайн оролцлоо.

1973 онд улсын хэмжээгээр 61 сургууль, цэцэрлэгийн барилга ашиглалтанд орсноос тус аймгийн Баянцогтод 320 хүүхдийн хичээлийн байр, Батсүмбэрийн ногоо тасагт 25 хүүхдийн цэцэрлэг, Зуунмод хотод 920 хүүхдийн хичээлийн байр тус тус ашиглалтанд орж, Зуунмод хотод 125 хүүхдийн цэцэрлэгийн барилга, Бүрэн суманд 440 хүүхдийн хичээлийн байр баригдаж байна.

Нам, засгаас жил бүр олон хүүхэдтэй эхчүүдэд олон сая төгрөгийн тэтгэвэр олгож байдаг билээ. Зөвхөн 1973 онд манай аймгийн 4572 эхэд буюу 24484 хүүхдэд 4 сая гаруй төгрөгийн тусламж үзүүлжээ. Манай нам, засгаас үр хүүхдийн төлөө тавьж байдаг хайр халамжийн үр дүнд үр хүүхэд маань сурч хүмүүжих сайхан бололцоогоор бүрэн хангагдаж жаргалант ирээдүйдээ итгэх төгс зорьж байна.

Манай өсвөр үе — үр хүүхдийн өмнө анги дэвших, сургууль төгсгөх шалгалтанд сайн бэлтгэх, 1975 онд болох улсын багш нарын зөвлөлтөө, МПБ-ын 50 жилийн ойг угтаж хөдөлмөр сурлагын өндөр амжилт гаргаж ёс суртахууны шилдэг чанарыг эзэмшин эх орон ард түмнийхээ ач тусыг хариулах хариуцлагатай үүрэг тулгарч байна.

Нам, ард түмнийхээ үйл хэрэгт хэзээ ямагт үнэнч үзлээр хүмүүжих нь манай өсвөр үеийнхний ариун үүрэг мөн.

Саарай төлөөлөгчөөр сонгогдов

Эрдэнэ сумын «Туяа» нэгдлийн малчин, МАХН-ын гишүүн Саарай энэ онд уралдаанд авсан үүргээ биелүүлэхийн тулд чармайлт гарганажиллаж 750 хонингоос 780 хурга, 22 ямаанаас 22 шигг хүлээн авч, төл том малын зүй бус хорогдолгүй байна.

МАХН-ын гишүүн хоньчин Саарай ийнхүү амжилт гаргаж аймгийн Намын XVI бага хуралд төлөөлөгчөөр сонгогдов.

Б. БАЛАНСҮРЭН

Баянцагаан сумын намын үүрийн нарийн бичгийн дарга Б.ЛХАМ, А.ДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга Д.НАМХАЙ нарт

МАХН-ын III их хурал, БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойг угтаж ямааны ноолуурын төлөвлөгөөг хугацаанаас нь 15 хоногийн өмнө 102,9 хувиар биелүүлж сайхан амжилт гаргасан танай сумын нам, улс, олон нийтийн байгууллага, малчид хөдөлмөрдөд баяр хүргэж, 1974 оны төлөвлөгөөт бусад зорилтуудыг амжилттай биелүүлнэ гэдэгт бат итгэж байна.

Аймгийн Намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Ц. АДЪЯА
Аймгийн А.ДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга Ч. ДАШДЭМБЭРЭЛ

Социалист хөдөлмөрийн Зам ашиглалтын ангийн хамт олонд

Социалист уралдаанд түрүүлэгчдийн чуулга уулзалтын уриалгыг биелүүлж, V таван жилийн төлөвлөгөөг 1 жил 9 сарын өмнө 103,3 хувиар биелүүлсэн, социалист хөдөлмөрийн Зам ашиглалтын ангийн хамт олонд хөдөлмөрийн цогтой халуун баяр хүргэе.

Машин техникийн хүч чадал, ажлын цагийн ашиглалтыг сайжруулан, дотоод нөөц бололцоог ашиглан, угтвар төлөвлөгөө, тооцоот үүрэг амлалттай ажиллаж V таван жилийн төлөвлөгөөний үлдэж байгаа хугацаанд их амжилт гаргана гэдэгт итгэж байна.

Аймгийн Намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Ц. АДЪЯА
Аймгийн А.ДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга Ч. ДАШДЭМБЭРЭЛ
Аймгийн ҮЭ-ийн зөвлөлийн дарга Н. ШАГДАРДАГВА

АЙМГИЙН НАМЫН XVI БАГА ХУРЛЫН ӨМНӨ НАМЫН УДИРДЛАГА, АЖЛЫН АМЖИЛТ

Баянцогт сум САА-н намын хороо, аймгийн намын XVI бага хурал угтаж зохиох ажлын төлөвлөгөө баталж, түүнээ биелүүлэх арга замын талаар хариуцлагатай, мэргэжилтнүүдийн нэгдсэн зөвлөлтөөр хэлэлцүүлж, хүмүүст тодорхой ажил хариуцуулсан байна.

Бага хурал угтсан өндөр бүтээлийн 30 хоногийн ажлын үндсэн зорилт нь хаврын тариалалтыг хугацаанд нь чанартай хийж дуусгах явдал байв. Үүний тулд социалист уралдаан өрнүүлэн тариачдын уралдааныг 3 хоногоор, бригадынхыг 6 хоногт дүгнэж, үзүүлэх сургууль зохиосны дүнд 17696 га-д үр тариа 20 гаруй мянган га-д хүнсний ногоо тариалах ажлыг ажлын 12—15 хоногт дуусгаж амлалтаа сайн биелүүлсэн 6 тракторчинд, БНМАУ-ын Ардын Их Хурлын депутат Ц. Очирын нэрэмжит шагналыг олгожээ.

Төл малын зүй бус хорогдолгүй ажиллах, малын ашиг шимийн төлөвлөгөөг биелүүлэх зорилтын дор ажилласан мал аж ахуйн фермийн хамт олон төлөө 99,5 хувиар бойжуулж тэмээний ноосыг 137,5 хувь, ямааны ноолуур, хялгасны төлөвлөгөөг 100 хувь биелүүлж, хөөврийн дутууг гүйцээхээр шамдаж байв.

САА-н намын хороо, мал аж ахуйн суурьдад МАХН-ын Төв Хорооны IX бүгд хурлын шийдвэр биелүүлэх боломжийг судлан, нийт суурийн 50 хувь, намын гишүүд 100 хувь биелүүлэх боломжтой гэж үзэж байна.

МАХН-ын гишүүн хоньчин А. Бадарч 565 хони-

ноос 572 төл бойжуулж, том малын хорогдолгүй байгаа зэрэг тэргүүний малчдыг олноор нэрлэж болох юм.

Сумын намын хороо, А.ДХ-ын гүйцэтгэх захиргаа төлчдийн уралдааныг 10 хоног тутам дүгнэн цуваагаар байр эзлүүлэн ажлын явцад нарийн судалгаа хийдэг болжээ.

Тэрчилэн намын гишүүдийн ажлыг тухайн үеүдэд цуваагаар байр эзлүүлэн дүгнэж гишүүдийн манлайллыг намын хурлуудаар хэлэлцэн зөвлөгөө өгч байна.

Тариалалт, төлбойжуулах, мал отордох зэрэг чухал ажилд намын гишүүд манлайлж бэлтгэлийг хангаад, түүн дээр үзүүлэх сургууль зохиож байгаа нь коммунистуудын манлайлал өссөнийг харуулах жишээ юм.

(Төгсгөл нь II нүүрт)



Зуны сарын эхэн, зургаан сарын нэгэн

хүүхэд бидний баяр, хөгжилтэй сайхан одор

ӨНӨӨДӨР ӨСВӨР ҮЕИИНХНИИ ИХ БАЯР



Бяцхан хүү Л. Д. Албш, Зуунмод хотын II сүлд олон монгол пайз нартай. Найрамдлын нэцгээр Монгол—Зөвлөлтийн хүүхдүүд эвсэг найртай хүмүүжиж байна.



Цэцэрлэгтээ «Манай Норовсамбуучууд» гэж алдаршсан үе тэнгийн энэ хоёр бяцхан охиныг Г. Туяа, П. Батцэцэг гэдэг. Энэ хоёр охиныг үгүй юм шиг уран нугаралтаа үзүүлэхэд нь цэцэрлэгийн найзууд нь үнэхээр бахархан харцгааж, бяцхан үзэгчид нээд хөөр болдог. Л. ДАМДИНДОРЖ, Б. ЦЭРЭНДАШ нарын авсан гэрэл зураг



Зуунмод хотын хоёрдугаар цэцэрлэгт хөгжим, дуунд авъяаслаг хүүхэд олон бий.

ЗУРАГ ДЭЭР:

Тэдний нэг хэсэг утсан хөгжим тоглож байгаа нь.

ҮР ХҮҮХЭД—ЭХ ОРНЫ БАХАРХАЛ

Би таван хүүхэд төрүүлж өсгөсөн эх хүн.

Миний хүүхдүүд нам, засгийнхаа хайр халамжаар ясли, цэцэрлэгээр хүмүүжиж одоо их хүү, охин хоёр маань дээд боловсрол эзэмшиж, дүү нар нь дээд, дунд сургуульд сурч байна.

Эцэг эхийнхээ төрүүлж өсгөсөн ач, нам, засгийнхаа сурган хүмүүжүүлсэн хайр халамжийн хариуд өндөр боловсрол мэдлэг эзэмшиж эх орныхоо хөгжил цэцэглэлтэд хувь нэмрээ оруулж алдар нэрээ дуудуулж яваа үр хүүхдээрээ эх хүн сэтгэл зүрхээрээ бахархаж явах юутай сайхан билээ.

Өнөөдрийн сурагч, оюутан та нар маргааш эмч, багш, инженер, барилгачин болдоггоо шүү дээ. Тиймийн тулд эх, орон-

доо гэрэлт сайхан ирээдүйг байгуулах их хувь тавилантай хүүхдүүд та нар минь заалгасан эрдмийг оюундаа шингээж, журналын хуудсан дээр багшийн тавьсан онц гэдэг эрхэм дүнг амьдрал хөдөлмөрийн талбарт анд нөхдөөрөө, ард түмнээрээ дүгнүүлж алдахгүй явах хэрэгтэй.

Амьдрал хөдөлмөр дээр авсан онц гэдэг тэр дүн чинь хөдөлмөрийн аварга, гавьяат, баатар гэсэн хэрэг шүүдээ.

Олон улсын хүүхдийн баярыг тохиолдуулан манай жавхлант ирээдүй мянга мянган пионер, баатарчууд та нартаа ямагт онц дүнтэй сурч, ажиллаж, амьдрахын ерөөл дэвшүүлье!

БНМАУ-ын хүний гавьяат их эмч Г. ДУЛАМЖАВ



Энэ бяцхан охиныг Адилзала гэдэг.

Адилзала олон шүлэг цээжиж, уран яруу уншдаг учир Зуунмод хотын II цэцэрлэгийнхэн уран уншигч гэж нэрлэдэг.

Сайхан манай сурвалжлагч бяцхан охиныг хүүхдийн баяраар шүлэг уншиж байхад нь зургийг нь авчээ.

Курганд ЗХУ-ын ач холбогдол бүхий гэмтэл согогийг судлан эмчлэх эрдэм шинжилгээний туршлагын томоохон институт ажилладаг.

Түүнийг анагаах ухааны доктор, РСФСР-ийн гавьяат их эмч Гаврил Абрамович Илизаров толгойлдог. Ясны төрөлхийн согог, хугарал гэмтлийг судлан ясыг сунгаж засах, өөрийн нь нөхцлөөр мэс засал болон эм хэрэглэхгүйгээр эмчлэх аппарат, эмчилгээний талаар анагаах ухаанд гайхамшигт шинэ нээлт гаргасан энэ домогт эмчээрээ Курганыхан ямагт бахархаж байдаг.

Энэ мужийн хөдөлмөрдийн соёл ахуйн үйлчилгээний салбарт түм гаруй хүн ажиллаж байна.

Хөдөө нутагт ахуй үйлчилгээний томоохон комбинат байгуулагдан ажиллаж байгаагийн зэрэгцээ хүн ам цөөнтэй тосгон, суурингуудад ахуй үйлчилгээний цэгүүдээр дамжуулан хөдөлмөрдийг үйлчилж байна.

Курганд номын сан, музей, кино театр, клуб амжилттай хөгжиж байна.

Энд зөвхөн суурин кино 1244 бий. Сайн дурын уран сайханчдын тоо 13000 гарчээ. Хот хөдөө-

гийн хөдөлмөрчид, телевизор, угаалгын машинаар үндсэндээ бүрэн хангагдаж хөдөө тосгон, суурин газрууд мал аж ахуйн механикжсан бригад эрчим хүчний нэгдсэн системд холбогдож, гэрэл цахилгаан, радио, цэвэр бохир усны холболт, шатаах хийгээр хангагдаж байна.

Курган мужийн хамтрал, САА-нууд, ХАА-н үйлдвэрлэлийг эрчимжүүлэх талаар хичнээн их зүйл хийж бүтээснийг Шадринскийн районы хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт «Улаан-ол» САА-н ажилтай танилцсанаас илт харагдаж байлаа. Энэ аж ахуй үйлдвэрлэлийн үндсэн дээр гахай үржүүлж, сүү, үр тарианы ажлыг дагнан явуулж, сүүлийн 12 жил дараалан ашигтай ажиллажээ.

Жилд 14 сая төгрөгийн борлуулалт хийж 5 сая рублийн ашигтай ажилладаг. Тус аж ахуй, мужаас улсад тушаадаг гахайн махны 20—30 хувь буюу 80 мянган тонн мах бэлтгэгдэж байна. Түүнчлэн 14 мянган га—д үр тариаралж га тутмаас 24 центнер ургац хураах болжээ.

Сүүлийн жилүүдэд үйлдвэрлэлийн эдийн засгийн

үр ашиг нь дээшилж үйлдвэрлэлд зарцуулсан нэг рубль тутмаас 2 рублийн ашиг олдог болжээ. Өндөр ашигтай ажиллаж байгаагаас энэ аж ахуй өөрийн хөрөнгөөр районы төв хүртэл 18 км засмал зам тавьсан ба бригад, фермүүд болон үйлдвэрийн тоочиж хүртэл засмал зам тавихаар төлөвлөн энэ жил 13 км зам тавихад 1,7 сая рубль зарцуулах ажээ. САА-н дарга Г. М. Ефримов тус аж ахуйд 15 жил ажилласан социалист хөдөлмөрийн баатар хүн юм. Энэ аж ахуйн тавьж байгаа нэг гол зорилт бол харьяандаа ажиллаж байгаа сургууль, эмнэлэг, ясли, цэцэрлэг зэрэг улсын төсвөөр ажилладаг байгууллагуудыг САА-н зардлаар санхүүжүүлэх арга хэмжээ авч эхэлжээ.

Аж ахуй, соёлын болон биеийн тамирын ордон барьж, засмал зам, мод, цэцэрлэг барьж байгуулах зэрэг олон арга хэмжээг хэрэгжүүлжээ. Цаашид залуучуудыг хөдөө нутагт суурьшиж үр бүтээлтэй хөдөлмөрдөхөд юу шаардлагатай бүрэн хангах зорилт тавин ажиллаж байна. Төв аймаг, Курган мужийн хооронд 1974 онд хамтран ажиллах тухай

хэлэлцээрт манай төлөөлөгчид тус мужид айлчлах хугацаандаа гарын үсэг зурсан юм.

Энэ хэлэлцээгээр халцан төлөөлөгч солилцон, мэргэжилтнүүдийг Курганд дадлага хийлгэх, тэргүүн туршлагаас суралцах, аймаг мужийн хөгжилтийг сурталчлах 7—10 хоногийн ажил зохиох зэрэг олон зүйлийг төлөвлөсөн юм.

Курган мужийн хөгжилтийг сурталчлах арга хэмжээний төлөвлөгөө болон тус мужийн үйлдвэр, аж ахуй, нам, олон нийтийн байгууллагын туршлагаас аймгийн аж ахуй, соёлын байгууллагуудад нэвтрүүлэх жагсаалтыг батлан ажиллаж байна. Курганд зочилсон төлөөлөгчдийг аймаг, сумын төвд уулзалт хийлгэх, Курган мужийн хөгжилтийн талаар булан үзэсгэлэн гаргах, сонин хэвлэл, радиогоор сурталчлах зэрэгээр тус мужийн хөгжилтийг төв, хөдөөд өргөн сурталчилж эхэллээ. Курган мужийн үйлдвэр, аж ахуй, нам, олон нийтийн байгууллагаас социалист уралдааныг хамт олон идэвх чармайлтыг бүрэн дайчлахуйцаар өрнүүлэг арга, уралдаанд түрүүлэгсдийг олон хэлбэрээр алдаршуулдаг, мэргэжил-

тэн, инженер—техникийн ажилтныг бүтээлч төлөвлөгөөтэй ажиллуулдаг, үйлдвэрийн тасаг, цех, бригад, ферм, хэсэг болон ижил ажил мэргэжлийн газар, ажилчдын хооронд уралдааны гэрээ байгуулж байгаа, залуу үеийнхнийг ахмадын хувьсгалч, хөдөлмөрч, дайчин уламжлалаар хүмүүжүүлж байгаа зэрэг олон тэргүүний туршлагыг ажилд нэвтрүүлэх аргачлал боловсруулан гаргаж амьдралд хэрэгжүүлэх дэд дараатай ажил зохиогдох болно. Ийнхүү манай аймаг, ЗСБНХОУ-ын Лениний одонт Курган мужтай байнгын шууд харилцаа тогтоон ажиллаж байгаа нь Монгол—Зөвлөлтийн ард түмний уламжлалт ган бат найрамдлыг улам зузаатган бэхжүүлж, Зөвлөлтийн баатарлаг ард түмний туршлага, хөдөлмөрч уламжлалаас суралцах сайхан бололцоог бий болгож өглөө.

Курганы ажилсаг хөдөлмөрч ард олны бүтээн байгуулалтын төлөө бүхий л оюун ухаан, хүч чадлаа хөвчлөн ажиллаж байгаа нөр их гайхамшигт хөдөлмөр нь манай аймгийн хөдөлмөрчдөд сайхан үлгэр дууриалал үзүүлнэ.

Сургуульд байхад үеийнх нь хүүхэд, ахаас: «Чи адуу манаж үзсэн үү? гэхэд

—Үүсэн, адуу манах сайхан шүү гэнэ. Нээрээ ч сайхан байхдаа гэж бодогддог байлаа. Ах минь олон адууны дэргэд морьтой, уурга барьж адуугаа харан саран одтой хар хилэн тэнгэр дор зогсож байгаагаар дүрслэгддэг байлаа.

Ах надаас гурав ах.

Намайг тавдугаар анги төгссөний зун манайх Яргайтад гүү сааж байв.

Аав хол юманд явж, ах эзгүй тул адууны манаа надад ноогдож билээ.

Би оройн гүү сааж, унагаа тавьсны дараа адуугаа бэлчээрт нь залан буцаж ирж хоол идэн айраг уугаад аавын зузаан цувьг эмээлийн хойгуур тохон адуу руугаа явж билээ. Адуугаа тогтоон байхад сартай шөнө, одод хайлсан цалин цагаан мөнгө мэт цэлэлзэн, тархан идэшилж буй адуу маань улам олон болсон мэт, хээр талд

адуу янцгааж, адуучин эрсийн гуугалах дуу, холд гялалзах машины гэрэл цөмийг ер өнө шөнө анх шинээр үзэх мэт сонихон.

Өдрийн халууныг зэвхэн дээр зогсч өнгөрөөсөн адуу шөнө нь шунах идэгийг мэдэв. Адуу үе үе янцгаахад сэтгэл сэр- гэнэ. Уулын гүнээс үнэгний хунах дуу сонсогдоно. Зуны шөнө хэдий бо- гино гэдгийг мэдэвч бу-

их л эсдлэг сайнаар хан- даж үерхдэг, саяхан ам- ралт эхлэхэд «хөдөөнөөс налад зурамны арьс ан- чирч өгөөрэй, бас захна бичээрэй» гээд үлдсэн үргэлж гээгэндээ цэнхэр тууз уяж явдаг охин, үеийн хөвгүүд бологдоно.

Найзууд маань эн д хамт бол ер айх юмгүй, харин ч ямар хөгжилтэй бол гэж санагдана.

Ингэсээр суутал шөнө дунд лав болсон доо.

гал ч байх шиг харлаад, моринь хөл доогуур бо- рооны ус горхи мэт ур- саад морь хальтчин урагш гишгэдэггүй.

Хэсэг адуу тогтоотол бас зүүн урд адуу янц- гаах нь дуулдав. Тэр адууны хойноос нилээд явтал үзэгдсэнгүй тул өнгөрчихөв үү гээд буцах гэртэл морь амаа булааж борооны хүйтэн ус хузуу хоолойгоор шавхуурдан жихүүцэн даарч унасан морь, уруудсан адуунд уур хүрэн нус, нулимс минь борооны устай цуг асгаран байсан даа.

Үүнээс хол уруудвал нэгдлийн тарианд хүрэх вий гэж улам ч цухалда- на. Гэтэл усархаг бороо гэнэт зогсч саран одод дахин гийв.

Адуугаа цуглуулан мо- риноос буун суухад га- зар нойтон, хувцас ху- нар чийгтэй. Удалгүй үд- шийн гялаан толгой дээр голлож үүр цайв. Айдуу- дын гэрээс утаа гарах хараахан болоогүй тул

мориноосоо буун цулбуу- раа барин сууж байтал нам унтжээ.

Адуу бүрэн, айл гэр харагдан шөнө өнгөрч ө- дөөний намуун тайванд сэтгэл санаа тайвшран бас урьд шөнийн явдалд алжаан унтсан хэрэг бай- жээ. Сэрвэл эмээлтэй морь алга.

Наран уулын толгой- ноос дээш хөөрөн манайх унагаа барьж байгаа ха- рагдана. Би адуу мана- сан анхны шөнийн дараах өглөө уургаа барьсаар явган харьж явтал ээжий өөдөөс морьтой, цагаан алчуур дэрвүүлсээр дав- хин айсуу.

Эмээлтэй морно алдаад унага татах цаг хождуу- лав гэж зэмлэх байхдаа гэж бодож байтал ээжий:

—Хүү минь яв. Эмээл- тэй морь чинь адуун дот- тор явж байхад нь их айлаа шүү. Шөнийн тэр айхавтар бороо гээ!

Би ер унтсангүй, санаа зовоод, хүү минь даараа уу? гэж билээ.

А.ЧУЛУУН

ЭХИЙН СЭТГЭЛ

ӨГҮҮЛЛЭГ


шуухан өглөө болоосой. Адуугаа сайн манаж адуучин хүн шиг харьж айл хотынхондоо магтуу- лах юмсан гэж хүсэмжлэ- нэ. Цулбуураа барин хэн- тэж амрахыг хүсэвч уул- хад сэрвийн шөнийн ха- ранхуйгаас ямар нэгэн амьтан гэтэж ирэх юм шиг бодогдоно. Багаас хамт тоглож, олдсон хэ- дэн чихрээ хувааж идэн, сүүлд нь сургуульд нэ- гэн ширээнд сууж, надад

Гэтэл уулын толгой- ноос бөөн хар үүл одлыг тагласаар нүүн ирж ха- ранхуй болов. Удалгүй анга нийлжнэн бороо ас- гарч адуу уруудав.

Би аавын цувьг өмс- сөнд хэлхийгээд морин дээрээс нэмээ шиг ун- жина. Бас хормой нь хий- сэхэд морь үргэх янзтай бас бусгахыг нь яанагээн.

Адуу хэд хэд тасарчээ.

Би адуугаа буцаах гэж яаравч урд маань гүн ан-



Нараа нараа наашаа, сүүдэр сүүдэр цаашаа
Найзаа найзаа наашаа, нартай цолоорво тоглоё

СПОРТ

СПОРТЫН ДЭВЖЭЭНД

2500 төгрөг хэмнэв

1974 оны 6 дугаар сард спортын дэвжээнээ дор дурьдсан уралдаан тэмцээнүүд болж, тамирчид авхаалж самбаа, хүч чаднаа сорин.

Шатрын олимпиад 5—10-нд Париж хотод, байт харвалтын олон улсын тэмцээн (Буриад АССР, Польш, Чехословак, Авст- ри оролцоно.) Улаанбаа- тар хотод 6—9-нд, хөнгөн атлетикийн олон улсын тэмцээн Прага хотод 11—19-нд, Варшав, Моск- ва хотод 20—25-нд.

Буудлагаар Буриад АССР-ийн тамирчидтай уулзалт Улан-үдэ хотод, хөдөөгийн залуучуудын III спартакиадын бүсийн III спартакиад бүсүүдийн төвд 28—29-нд, шигшээ уралдаан Улаанбаатар хотод 7 дугаар сарын 4—7-нд, мотоспортгоор Крас- ноярскийн тамирчидтай уулзалт Улаанбаатар хо- тод, Бөхийн чөлөөт ба- рилдааны бүсийн тэмцээн 15—16-нд Ховд, Баянхон- гор, Архангай, Төв, Дор- ноговь, Өвөрхангайн төвд явагдаж, шигшээ тэм-

цээн Баянхонгор аймагт 21—22-нд.

Спортын мэдээ сонинь нэрэмжит дугуйн тэм- цээн 22—23-нд.

Монгол, Таджик, Эр- хүүгийн дугуйчдын олон өдрийн уралдаан Улаан- баатар—Эрхүү, Улаанбаа- тар дамжин 6-нд урал- дана. Хоршооллын шуга- маар социалист орнуудын эмэгтэй волейболчдын олон улсын тэмцээн (Польш, Унгар, Болгар, Чехословак, Румын зэрэг оролцоно.) Улаанбаатар хотод 17-23-нд, Хоршоол- лын шугамаар дугуйчдын спартакиад Румынд яваг- дана. ЗХУ-ын хурдач ра- диодистуудтай хамтарсан бэлтгэл хийх Улан-үдэ хотод. Аймгийн хөдөө- гийн залуучуудын III спартакиад, эмэгтэйчүү- дийн анхдугаар спарта- киад 8—9-нд Зуунмод хо- тод тус тус явагдана.

УРГАЦ НИЙГЭМЛЭГ

Аймгийн авто тээврийн XIII баазын жолооч Ж.Цэрэндорж бүх ард түмний уралдааны жил—1973 оны төлөвлөгөөг 219 хувиар биелүүлэн ачаа тээврийн аварга болсон амжилтандаа тул- гуурлан БНМАУ-ын тээв- рийн байгууллагын 50 жи- лийн ой угтаж 1974 оны социалист уралдаанд то- дорхой үүрэг авч 1974 оны I улирлын төлөвлө- гөөг 15 хоногийн өмнө 100—150 хувиар биелүүлж резин дугуй, сэлбэг ма- териалаас 2500 төгрөгийн арвилан хэмнэлт гаргаж хамт олноо хошуучилж байна.

П.ДАМБАДАРЖАА

Анчдын цэц

Батсүмбэр сум чоно ав- лах 6 бригад гаргаж 38 бэлтрэг агнасны дотор анчин өвгөн Аюуш 11 бэлтрэг, Гомбо 9 бэлт- рэг агнав.

Р.ЦЭРЭН

УРАН ГАР—ӨНГӨТ ХИВС

МХЗЭ-ийн илгээлтээр манай о р и ы үйлдвэр, ХАА-д мянга мянган хөв- гүүд гарч ахмадынхаа халааг авч хөдөлмөрийн бахдам амжилт гаргаг- гааж байна.

Тэдний нэг нь НААУ- ний хивсчин Ш.Төгсбаяр юм. Одоогоос 9 жилийн өмнө аймгийн төвийн 10 жилийн дунд сургуулийн аравдугаар ангийг ам- жилттай төгссөн Ш.Төгс- баяр шинээр байгуулагд- сан хивсэн тасгийн хаал- гыг татаж хүн ардынхаа хэрэгцээнд хивс үйлдвэр- лэх хүндтэй бөгөөд на- рийн мэргэжил сонгон авч тэргүүний ажиллагаа- тай хивсчний нэг болжээ.

Хивс нэхэхийн тулд эхлээд ямар хээ, өнгө, хэмжээтэй байхыг цаасан дээр зурж тооцдог юм. Тийм болохоор хивсчин хүнээс зураг, тоо бодло- гын зохих мэдлэг шаард- даг. Манай хамт олны үйлдвэрлэсэн хивсэнд аймгийн УЭ-ийн зөвлөл,

төлөвлөгөөний комиссоос «Онцсайн» чанарын гэр- чиглээ олгосонд бид их баяртай байна.

Энэ жил «Зуунмод» хивс үйлдвэрлэж байна.

Хивсчин хүний анхаарч ажиллах гол зүйл нь хивс- ний зургийг сайн зурж, зургаа зөв уншиж, тооцоо нарийн хийж, цагийг үр бүтээлтэй ашиглах явдал юм. Том зургаа хараад хивсний хатгаш бүрийг зөв тоолж нэхэж байвал сая хээ зөв гардаг.

Бид нэхмэлийн үйлдвэр- рийн хаягдал утсыг ашиг- лаж хивс нэхэж байна гэж яриу.

Хивсчин Ш. Төгсбаяр социалист уралдаанд ав- сан үүргээ амжилттай биелүүлж 1973 оны тө- лөвлөгөөг 128,9 хувь, 1974 оны I улирлын тө- лөвлөгөөг 111,3 хувиар биелүүлж МХЗЭ-ийн ил- гээлтийн ээдийн аймгийн чуулга уулзалтанд оролц- сон юм.

Р.БАЯРСАЙХАН

ГУРВАН ҮЗҮҮЛЭЛТЭЭР

Өндөрширээт сумын холбооны салбар социа- лист уралдааныг эрчим- тэй өрнүүлж 1974 оны эх- ний хагас жилийн орло- гын төлөвлөгөөг үзүү- лэлт бүрээр нь 102—105 хувь, солилцооны төлөв- лөгөөг 105—150 хувь, хол-

боо хөгжүүлэх төлөвлө- гөөг 100 хувь биелүүлжээ.

Мөн Борнуур сум-САА, 1974 оны аж ахуйн төлөв- лөгөөгөөр өгөгдсөн бо- дын хөөвөр, хялгасыг 104-108,2 хувь, ямааны ноо- луур, хялгасыг 101—101,5 хувиар биелүүлж, тээвэр- лэж дуусгасан байна.

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧ

Д.ТОВУУ

ЗАРЛАЛ

Эрдэнэсант сумын харьяат Ням овогтой Санжаа нь мотоцикл жолоодох эрхийн 13262 тоот үнэмлэхээ гээгдүүлсэн тул хүчингүйд тооцов.